

**МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ТӨВ НОМЫН САН**



ШИНЭ НОМЫН МЭДЭЭ

№11

2013.03.14

Эмхтгэсэн: Ном зүйч М. Кунай

Ном зүйч Д. Алтанзул

**Электрон каталоги:
<http://catalog.num.edu.mn>**

ЦӨЛЖИЛТ, ХИМИ, БАЙГАЛИЙН ОРГАНИК ХИМИ



Цөлжилтийн эсрэг: Бодлого, судалгаа, технологи, үйл ажиллагаа. – УБ.: 2007. – 112 х.

Тус товхимолд ЦСТ-өөс 2007 оны 5-р сарын 24 ний өдөр зохион байгуулсан цөлжилттэй тэмцэх туршлага, үр дүн сэдэвт семинарт оролцсон холбогдох яамдын бодлогын талаарх мэдээлэл, эрдэм шинжилгээний байгууллагуудын төлөөлөгчдийн судалгаа шинжилгээний ажил, Төв Азийн бүсийн зарим, Хятад улсын туршлага, Монгол улс дахь олон улсын байгууллагуудын төслүүдийн үйл ажиллагаа зэрэг олон төрлийн мэдээллийг багтаажээ.

20.1

Ц-81

T-16097-16098

Адьяасүрэн П., Жаргалсайхан Б., Дашлхам Д. **Органик бус хими:** Их дээд сургуульд элсэгчдэд, химийн болон байгаль шинжлэлийн багш нарт зориулав /Хян. Б. Жаргалсайхан. – УБ.: 2013. – 338 х.



Сурах бичигт ерөнхий хими, элементийн химийн онолын суурь мэдлэг болон комплекс нэгдлийн химийн товч мэдлэг, химийн гол хууль, органик бус бодисын үндсэн ангилал, химийн урвал, уусмалын хими, металл бус элементүүд тэдгээрийн нэгдлүүдийн шинж, металл элементүүдийн нэгдлийн шинж гэсэн 8 бүлэгт авч үзэхийн хамт бүдүүвч, хүснэгт, зураг, химийн урвалыг түгээмэл хэрэглэснээрээ өмнөх сурах бичгээс онцлог байгаа нь сэдэв хоорондын гинжин холбооны мөн чанарыг нээж үзүүлэхэд чухал ач холбогдолтой болгожээ. Мөн ЕБС-ийн сургалтын хөтөлбөрийг бүрэн багтаахаас гадна химийн гол хуулиудаар бодлого бодох загвар, жишээ бодлого бодолтыг оруулжээ.

24.1

A-29

/БШУН унш- 35ш/

B-22376-22380



Биндэръяа М., Бөхчулуу М., Энхсүрэн Э. **Флавоноидын физик, химийн судалгаа:** Эмийн ургамал судлаач, химичид, эм зүйн төгсөлтийн болон төгсөлтийн дараах

сургалтын оюутнууд, эм зүйч нарт зориулав /Хян. Д. Найдан. – УБ.: Шидэт өнгө, 2012. – 148 х.

Манай орон эмийн ургамлын нэр төрөл, нөөцийн хувьд нэлээд баялаг бөгөөд сүүлийн 20-иод жилд тэдгээрийн шинжлэх ухааны судалгаа зохих үр дүнд хүрчээ. Энэхүү номыг үндсэн 6 бүлэгт хуваажээ. Үүнд: 1. Флавоноидын бүлэг нэгдлүүдийн тухай товч тодорхойлолт, тэдгээрийн ангилал, 2. Флавоноидын ургамал дахь биосинтез, 3. Флавоноидын биологийн идэвх, 4. Флавоноидын бүтцийн судалгаанд спектрийн аргыг хэрэглэх нь, 5. *Carduus crispus* L. ургамлаас ялгасан Флавоноидуудын бүтэц байгуулалтыг спектрийн аргуудаар судалсан дүнгээс, 6. Люминесценцийн төрлүүд гэсэн гол бүлгүүдийг дотор нь хуваан судлан авч үзжээ.

24.239

Б-48

/БШУН унш-7ш/

Т- 16076-16078

Ганбаатар Ж., Отгонсүрэн Д., Энхжаргал Б. **Англи-Монгол-Орос химийн нэр томъёоны толь бичиг** /Ред. М. Баяржаргал. – УБ.: ТЕГ, 2012. – 107 х.



Тус химийн нэр томъёоны Англи-Монгол-Орос хэлний товч толь бичиг нь органик биш хими, органик хими, физик хими, биохими, энзимологи, нефть, ба хийн хими зэрэг химийн олон салбар шинжлэх ухаанд хэрэглэгддэг нэр томъёо, 4500 үг агуулснаас гадна химийн лабораторийн тоног төхөөрөмжийн нэр томъёог ч оруулсан болно.

24я2

Г-21

/БШУН унш-25ш/

Б-22361-22365

[УУР АМЬСГАЛ СУДЛАЛ, УС СУДЛАЛ](#)



Бүс нутгийн уур амьсгалын өөрчлөлт ба экосистемд учрах аюул: Дугаар- 1. Алтай-Соёны экобүс нутаг /Эмх. Д. Баннер ба бус, Орч. Д. Нарангэрэл., Н. Батсүх. – УБ.: Адмон. – 23 х.

Алтай-Соёны уулсын орон нь ДБХС-аас тодорхойлсон, манай гарагийн биологийн төрөл зүйлийн 90% гаруй нь төвлөрөх, унаган төрхөөрөө эсвэл өөрчлөлтөнд бага

нэрвэгдсэн –“Global 200” бүс нутгийн жагсаалтанд багтдаг. Сэрүүн уур амьсгал, өвөрмөц тогтоц нь ургамал, амьтны аймгийн олон төрөл хэлбэрийн давтагдашгүй байдлыг нөхцөлдүүлнэ. Тус бүс нутаг нь нийт 1065300 хавтгай дөрвөлжин км талбайг эзэлж, баруунаасаа дорно зүг 2000 км, өмнөөс хойд цэг хүртлээ 1500 гаруй км үргэлжилнэ. Ойролцоогоор газар нутгийн 62% нь ОХУ-д, 29% нь Монголд, 5% нь Казакстанд, 4% нь Хятад улсын нутаг дэвсгэрт хамаардаг байна.

26.237

Б-88

Т-16099

Орхон голын сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө боловсруулахад зориулсан судалгааны эмхэтгэл /Хян. Г. Долгорсүрэн., Ц. Балдандорж. – УБ.: 2012. – 470 х.




Орхон, Туул, голын сав газрын болон улсын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг боловсруулахад шаардагдах мэдээ мэдээллийг бүрдүүлэхийн тулд тухайн сав газрын болон Монгол орны байгалийн нөхцөл, уур амьсгалын өөрчлөлт, түүнээс усны нөөцөд үзүүлэх нөлөөлөл, гадаргын болон газрын доорх усны нөөц, горим, усны чанар ба экологи, амьтны аймаг газар ашиглалт, нийгэм, эдийн засгийн хөгжил, сав газрын ус хэрэглээ-ашиглалтын өнөөгийн байдалд судалгаа хийж үнэлгээ өгөн, цаашдын чиг хандлага, хэтийн төлөвийн талаар төслийн багийн гадаад, дотоодын мэргэжилтэн, зөвлөхүүдийн хамтран бичсэн тайлангуудыг нэгтгэн энэ эмхэтгэлүүдийг гаргажээ.

26.22

О-48

Т-16116



Туул голын сав усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө боловсруулахад зориулсан судалгааны эмхэтгэл /Хян. Г. Долгорсүрэн ба бус. – УБ.: 2012. – 598 х.

26.22

Т-70

Т-16115

Улсын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө боловсруулахад зориулсан судалгааны эмхэтгэл: Дэвтэр-1.2.3 /Хян. Долгорсүрэн, Эмх. Б. Батцэцэг. – УБ.: 2012.



26.22

У-31

ДЭВ-1. – 608 х.

T-16112


ДЭВ-2. – 486 х.

T-16113

ДЭВ-3. – 436 х.

T-16114

БИОЛОГИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ЭРДЭМТЭДИЙН НАМТАР, УРАН БҮТЭЭЛ



Богд хан уулын байгалийн атлас /Хян. Ц. Адъяасүрэн, Ц. Шийрэвдамба. – УБ.: 1998. – 39 х.

28.088лб/яб

Б-52

T-16100

Академич, профессор Н. Даваа. – УБ.: 1998. – 62 х.

Монгол улсын гавьяат багш, академич, биологийн ухааны доктор, профессор Н. Даваагийн мэндэлсний 65 насны ойг тохиолдуулан гэр бүл, үр хүүхдүүд, төрөл төрөгсөд, найз нөхөд, мэргэжил нэгт нөхөд, шавь нар нь дурсамж, сэтгэгдэлээ бичсэнийг түүний намтар, бүтээлийн жагсаалтын хамт энэхүү дурсамжийг хэвлүүлжээ.



28г

А-39

Б-22401-22402



Түвдэнгийн Гун-Аажавын монгол улсын их сургуульд суралцаж, ажилласан хагас зуун жил /Эмх. М. Цогбадрах, Ред. Г. Манлайжав. – УБ.: Мөнхийн үсэг, 2009. – 147 х.

Монгол улсын гавьяат багш, физик-математикийн шинжлэх ухааны доктор, профессор Т. Гун-аажавын амьдрал бүтээлийг өгүүлсэн энэхүү номонд багшийн ажил, амьдралын он цагийн хэлхээс, бүтээлийн жагсаалт, ажил байдлын тодорхойлолт болон

багш нар, анд нөхөд, шавь нарын дурсамж, сэтгэгдэл, фото зургийн цомог зэрэг түүхэн баримтуудыг багтаан оруулжээ.

28г

T-73

T-16087

Хөтчин овогт Цагаанбандийн Цэндээхүү: Намтар, бүтээл. – УБ.: МУИС-ийн хэвлэх, 2013. – 48 х.



БШУ-ны доктор /ScD/, профессор Ц. Цэндээхүү багш бол МУИС-ийн Ургамал судлалын тэнхимын анхны төгсөгч бөгөөд 1965 оноос тус тэнхимд 50 шахам жил амжилт бүтээлтэй ажиллаж ирсэн ууган, ахмад багш нарын нэг, ботаникийн тэр дундаа ургамлын физиологийн сургалт судалгааг үүсгэн хөгжүүлж, шавь сургууль бий болгосон нэр хүндтэй эрдэмтэн билээ. Ургамал судлалын 50 жилийн ойгоор Ц. Цэндээхүү багшийн товч намтар, бүтээлийн жагсаалтыг нь хэвлүүлжээ.

28г

X-62

T-16084-16086

Цагаанбандийн Цэндээхүү: Намтар, бүтээлийн жагсаалт /Эмх. Ц. Жамсран., Самъяа, Ред. Д. Сумъяа ба бус. – УБ.: 1998. – 24 х.

28г

Ц-12

B-22403-22405

Эволюцийн онол ба биологийн шинжлэх ухаан : Их Британы нэрт эрдэмтэн, эволюцийн онолыг үндэслэгч Чарльз Роберт Дарвины мэндэлсний 200 жилийн ой, Монгол улсын гавьяат багш, академич Осорын Шагдарсүрэнгийн мэндэлсний 80 насны ойг тохиолдуулан зохион байгуулсан эрдэм шинжилгээний бага хурлын материал /Ред. Б. Баяртогтох. - УБ.: МУИС-ийн хэвлэх, 2009. – 59 х.



Тус эмхэтгэлд нь эрдэм шинжилгээний хуралд тавигдсан илтгэлүүд, эссе бичлэгийн уралдаанд шагналт байр эзэлсэн оюутнуудын ирүүлсэн бүтээлүүд болон академич О. Шагдарсүрэнтэй олон жил хамт ажиллаж байсан эрдэмтэд, шавь нарых нь дурсамж, сэтгэгдэл зэрэг орсон байна.

28г

Э-13

/БШУН унш-2ш/

T-16092-16093



“Алтайн өвөр говийн экосистемийн зарим судалгааны тойм: Эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл /Ред. Я. Адъяа., К. Улыкпан. – УБ.: 2004. – 206 х.

Алтайн өвөр говьд хийсэн судалгааны ажлуудын гол дүнг нэгтгэн дүгнэж цаашдын судалгааны ажлын чиглэлийг тодорхойлох, өмнө нь хийгдэж тодорхой үр дүн өгсөн буюу одоо зарим эрдэм шинжилгээний байгууллагад хийж буй судалгаа шинжилгээний ажлыг давхардуулан хийхгүй байх зорилгоор зохион байгуулсан эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийг энд эмхэтгэжээ.

28.688

A-48

T-16095-16096

[ХЭВЛЭЭР ЯВАГЧИД, ИРВЭС, МИНЖ](#)

Монгол орны хоёр нутагтан, мөлхөгчдийн хамгааллын төлөвлөгөөний эмхэтгэл /Эмх. Х. Тэрбиш ба бус, Ред. М. Мөнхбаатар ба бус. – Лондон.: ZSL, 47 х.

28.693.34/1/

M-69

/БШУН унш-1ш/

T-16105-16106



Монгол орны хоёр нутагтан, мөлхөгчдийн улаан данс /Эмх. Х. Тэрбиш ба бус., Ред. М. Мөнхбаатар ба бус. – Лондон.: ZSL, 77 х.

Энэхүү бүтээлүүдийг Лондоны Амьтан Судлалын Нийгэмлэгээс эрхлэн гаргаж буй бүс нутгийн улаан данс цувралуудын хэсэг юм.

28.693.34/1/

M-69

/БШУН унш-2ш/

T-16107-16108

Монгол орны цоохор ирвэс. – УБ.: 2003. – 24 х.

Цоохор ирвэс дэлхийд нэн ховордсон устаж болзошгүй, махчин амьтан. Монгол орны болон байгаль, байгалийн нөөцийг хамгаалах олон улсын холбооны улаан номонд бүртгэн, зэрлэг амьтан ургамлын аймгийн ховор, ховордсон зүйлийг олон улсын



хэмжээнд худалдаалах тухай /CITES/ Вашингтоны конвенцийн 1-р хавсралтанд оруулж, агнахыг хориглосон.

28.688/1/

M-69

T-16094



Нөмрөгийн дархан цаазат газрын менежментийн төлөвлөгөө /2001-2005/. – УБ.: 2001. – 94 х.

Нөмрөгийн ДЦГ-ын менежментийн энэхүү төлөвлөгөөнд тус ДЦГ-ын нутаг дэвсгэрт гарч буй, гарч болзошгүй зөрчлийг арилгах, улмаар түүнд нөлөөлөх гадны хүчин зүйлийн сөрөг нөлөөллийг багасгахад чиглэгдсэн болон хамгаалалтын бусад арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэхээр тусгасан болно.

28.088я6

H-78

T-16101

Самъяа Р., Шар С., Доржраа О. **Минж.** – УБ.: Мөнхийн үсэг, 2012. – 140 х.



Энэхүү номонд эрдэмтдийн бичиж боловсруулсан минжний тархалт, амьдрах орчин, ач холбогдолын талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөх бөгөөд “Экологийн инженер” гэж олон улсад алдаршсан энэ амьтныг авран хамгаалах ажлыг дэлхий дахинаа болон манай оронд өрнөсөн ажил, одоо шинээр эхэлж байгаа төслийн санааг товч тусгасан мэдлэг, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлах, энэ чиглэлийн ажил эрхэлдэг мэргэжлийн хүмүүс, байгаль хамгаалагчид, сонирхогчдод туслах зорилгоор энэхүү гарын авлагыг нийтэд зориулжээ.


28.693.36

C-26

/БШУН унш-3ш/

Б-22384-22386

ДАРХАН ЦААЗТАЙ ГАЗАР НУТАГ, АМЬТНЫ ХАМГААЛАЛ



Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээ: Үнэлгээ, өргөжүүлэх асуудал /Ред. Д. Даш. – УБ.: Адмон, 2002. – 228 х.

Энэхүү эмхэтгэлд ТХГНС-нд үнэлгээ өгөх,

өргөжүүлэх асуудлыг хөндөж шинжлэх ухааны экспэртүүдийн ажлын хэсэг шаардагдах үзүүлэлтүүд, индикаторууд, арга зүйг сонгож нэн тэргүүнд анхаарлаа хандуулах газар нутгийн сонголтыг гаргасан дүгнэлтийг толилуулж байна.

28.088л6

T-69

T-16103

Хотолхүү Н. **Хэнтийн булганы экологи, аж ахуйн холбогдол**: Биологийн ухааны дэд эрдэмтний зэрэг горилон бичсэн бүтээл. – УБ.: Икспресс, 1982. – 148 х.



Эрдэмтэн хөхтөн судлаач Н. Хотолхүүгийн энэхүү нэгэн сэдэвт Хэнтийн булганы ангилал зүй, тархац, орших нутаг, тэжээл-идүүлэгчийн тоонд нөлөөлөх тухай болон популяцийн бүтэц, нас, өсөлт, булганы тоо толгойн байдал, агнуурын холбогдол, хэтийн төлөв нутагшуулан үржүүлэх боломж зэрэг манайд огт судлагдаагүй байсан олон асуудлыг хамарч тал бүрээс нь шинжлэх ухааны үндэстэй бүтээлийг нь нийтийн хүртээл болгожээ.

28.693.36

X-50

/БШУН унш-7ш/

Б-22387-22389



Хөвсгөлийн улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалал, судалгаа, мониторинг: “Өнөө ба ирээдүй”: Эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл /Эмх. Р. Самьяа, Орч. Н. Туяа. – УБ.: Адмон, 2010. – 187

х.

Энэхүү эрдэм шинжилгээний бага хуралд ШУА-ийн Гео-экологи, Биологи, Газар зүйн хүрээлэн, их сургуулийн эрдэмтэн судлаачид, оюутан залуус, байгаль хамгааллын төрийн ба төрийн бус байгууллагын ажилтнууд, ОХУ-ын эрдэмтэд, байгаль хамгааллын салбарын ажилтан, орон нутгийн төлөөлөл оролцжээ. Хурлаар Хөвсгөлийн Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгааллын бодлого, өнөөгийн байдал, хөгжлийн шинэ хандлага, Хөвсгөл нуурын түүхэн хөгжил, уур амьсгал, биологийн олон янз байдлын судалгааны зарим дүн, урьд өмнө хийсэн судалгааны тоймыг тусгасан илтгэлүүдийг хэлэлцсэн болно.

28.088л6

X-53

T-16102

Хэйр Жон. Говийн хаан: Хавтгай тэмээний тухай өгүүлэх нь /Хян. Н. Сарантуяа. – 27 х.



Монгол улс олон зүйлийн гайхамшигтай сонин хачин зэрлэг хөхтөн, шувууны орон билээ. Өнөөдөр эдгээрийн цөөнгүй хэсэг нь ховордож, устах аюул нүүрлээд байна. Гайхамшигтай хөхтөн хавтгай тэмээ ч устахын ирмэг дээр иржээ. Энэ сонирхолтой хоёр бөхт амьтан говь цөлийн гүнд амьдардаг. Говь цөлийн нөхцөл тааламжгүй учир тэнд цөөхөн амьтан нутагладаг. Хавтгай тэмээ ийм нөхцөлд яаж амьдардаг тухай бичсэн энэхүү сонирхолтой номыг Ж. Хэйр хүүхэд та бүхэнд хандуулжээ.

28.688

X-89

Б-22399-22400

ХЭМЖИЛЗҮЙ, КОМПЬЮТЕР



Итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллагын лавлах мэдээллийн товхимол /Хян. М. Мөнгөнбаяр., С. Ганцэцэг. – УБ.: СХЗГ, 2012. – 947 х.

Энэхүү хэвлэлд нь 2012 оны 01-р сарын 01-ний өдрийн байдлаар Монгол Улсын Итгэмжлэлийн байгууллагаар итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллагууд /сорилт, хэмжилзүйн лаборатори, баталгаажуулалтын байгууллага/-ын танилцуулга, итгэмжлэлийн хүрээг агуулжээ.

30.604.6ц

И-92

T-16109

Мөнхчимэг Б., Болор Л. Компьютерийн мэдлэг: Сурах бичиг /Ред. С. Наранхүү. – УБ.: Мастерлайн, 2012. – 408 х.



Компьютерийн мэдлэгийн түвшинг тогтоох /Европын/ компьютерийн боловсролын гэрчилгээ олгох сургалтын багш хөтөлбөр болох үндсэн 7 модуль хөтөлбөрийн дагуу компьютер ашиглах ерөнхий мэдлэг, хэрэглээний

програмуудыг ашиглах загвар, зөвлөмж, командуудын тайлбар, нэр томъёоны тайлбар толь, өөрийгөө сорих тест, үгийн сүлжээ, мэдлэгт нэмэр болох зөвлөмжүүдийг хамт оруулжээ.

32.973я73

М-81

/БШУН унш-7ш/

Т-16121-16123

АНГИЙН АЖ АХУЙ, ЖИЖИГ АМЬТАДЫН ЛАБОРАТОРИЙН ТУРШИЛТ



Даш Я., Гонгор Ш. **Ан агнуурын товч мэдэгдэхүүн**
/Ред. Л. Раднаа. – УБ.: АЦСХ хэвлэх, 1965. – 73 х.

Энэ товхимолд ан агнуурын бүтээгдэхүүний үйлдвэрлэл, ан агнуурын хугацаа, ангийн хууль, ангийн үс, ан агнуурын бүтээгдэхүүн бэлтгэлийн тухай, ан амьтдын нөөц баялгийг арвижуулах, ан агнуурын аж ахуйг нөхөн үйлдвэрлэлийн талаар болон ан сонирхогчид, залуу анчдад зөвлөгөө санамж, ан агнуурын сахилга бат, хөдөлмөр хамгааллын тухай товч өгүүлэх аж.

47.1

Д-39

Б-22393

Галиндэв Б., Насанжаргал Д., Цэрэнсүрэн Х. **Лабораторийн туршилтанд жижиг амьтдыг хэрэглэх нь: Гарын авлага** /Хян. Я. Ганболд. – УБ.: Артсофт, 2010. – 113 х.



Уг товхимолд лабораторийн амьтан ашиглан шинжилгээ, судалгаа, сорилт, туршилт ойлгоцын талаар 155 бодит зураг, нэлээдгүй хүснэгт гарган үзүүлжээ. Энэхүү номыг биологи, хүн, мал эмнэлэгийн салбарын судлаачид, их дээд сургуулийн оюутнууд ашиглах нь нэн тохиромжтой.

48в6

Г-19

/БШУН унш-7ш/

Б-22342-22344

ЭМ СУДЛАЛ, БИОБЭЛДМЭЛ ҮЙЛДВЭРЛЭЛ



Галиндэв Б., Баярсайхан Ж. **Биобэлдмэлийн чанарын хяналт, лабораторийн ажлын гарын авлага** /Хян. Х. Цодой. – УБ.: Согоо нуур, 2008. – 106 х.

Энэхүү гарын авлаганд энэ чиглэлийн мэргэжлийн ном, лавлагаа-материал ховор байгааг харгалзан биобэлдмэлийн чанарын асуудалтай холбоотой шинэ шаардлага, нөхцлийг бодолцож таны мэдлэгийн хүрээнд нэмэр болгох, микробиологийн үйлдвэрлэлийг тодорхой хэмжээгээр ойлгуулах зорилгоор зураг, диаграмм, харьцуулсан хүснэгт гарган харуулжээ.

52.81

Г-19

/БШУН унш-7ш/

Б-22348-22350

Галиндэв Б., Лувсан Ж., Цэцэгдарь Ч. **Биобэлдмэл үйлдвэрлэлийн анхан шатны гарын авлага.** – УБ.: 2007. – 89 х.



Толилуулж буй биобэлдмэлийн анхан шатны энэ номонд омгуудын морфологи, тэдгээрийг таних арга, өсгөвөрлөх технологи, шинж чанар, бэлтгэсэн биобэлдмэлүүдийн идэвхит чанарыг тодорхой бичиж, илрэх эмгэгийг өнгөт зураг, тооны үзүүлэлтээр гаргаж тодорхойлсон нь цаашид судлах, шинэ арга нэвтэрүүлэх, суурь мэдлэг олж авахад тань туслана.

52.81

Г-19

/БШУН унш-7ш/

Б-22345-22347

НИЙГМИЙН ШИНЖЛЭХ УХААН



Железняков А.С., Тикунов В.С. **Монгол улсын тогтвортой хөгжлийн атласын онолын үндэслэл** /Орч. Ч. Даваадаш ба бус. – УБ.: 2012. – 220 х.

Толилуулж буй энэ ном Монгол төвтэй Өвөр Азийн эргэн тойронд, тухайлбал, түүний нөлөөний хүрээ түүх соёлын бусад томоохон нэгтгэлүүд соёл иргэншлүүдийн тойргууд хоорондоо холилдон сүлжилдсэн бүсэд гарч буй гүн гүнзгий улс төрийн өөрчлөлтүүдийг судлахад зориулжээ. Энэ нь Монголын

байр байдал үүргийг эдийн засаг, улс төрийн нөлөөний дэлхийн төвүүдийн өөр хоорондын харилцааны тогтолцооны хүрээнд авч үзэж судлах нь глобаль улс төрийн хүчнүүдийн байрлал хувиарлалтын зарим нарийн төвөгтэй асуудлыг тодруулан тайлбарлахад туслах болно.

60.56/1/

Ж-48

/НХШУН унш-3ш/

Б-22318-22319

Шилжилтийн нийгэм: Шинэтгэл, соёл иргэншлийн асуудлууд /Орос, Монголын жишээгээр авч үзэх нь/ /Ред. А.С. Железняков, Орч. Ч. Даваадаш. – УБ.: 2012. – 264 х.




60.56

Ш-63

/НХШУН унш-3ш/

Б-22316-22317

ТҮҮХИЙН ШИНЖЛЭХ УХААН



Авирмэд Д. Дүрвэх хөдөлгөөн ба улсыг аюулаас хамгаалах байгууллага /1930-1934/ /Хян. Р. Болд., Ж. Урангуа. – УБ.: ТЕГ хэвлэх, 2012. – 134 х.


Түүхч Д. Авирмэд нь Монгол Улсын Тагнуулын байгууллагын 90, Тусгай архивын 80 жилийн ойд зориулан гаргасан энэхүү номондоо ХХ зууны Монголын түүхийн нэгэн зангилаа асуудлууд ялангуяа 1927-1928 оны үеийн улс төрийн үйл явцын шууд үр дагавар болох гучаад оны эхэн үед тус улсын хүн ам олноороо хилийн чанадад дүрвэн гарах хөдөлгөөн, түүнд нөлөөлсөн хүчин зүйлс, тэрхүү дүрвэх хөдөлгөөнийг таслан зогсоох, дүрвэн гарсан иргэдээ буцаан авчрах талаар төрөөс баримталсан бодлого, түүнд тагнуулын байгууллагын гүйцэтгэсэн үүрэг, оролцоог архивын шинэ мэдээ, баримтанд тулгуурлан тухай үеийн бодит байдал болон түүхэн сургамжтай ном бичсэн байна.

63.3/1/62

А-17

Б-22320-22321

Балжинням Б., Батсуурь Ж., Цогтбаатар А. Дэлхийн монголчуудын түүх: Боть. 1-9. – УБ.: Адмон, 2012.



Эзэн Чингис хааны мэндэлсний 850 жилийн ойд зориулсан “Дэлхийн монголчуудын түүх” энэхүү номын 1-р ботид: Эртний дурсгал судлалын олдворууд, үл хөдлөх дурсгал болон биет бус соёлын өвүүдийн судалгаа, угсаатны зүйн судлал хэрэглэгдэхүүн, 2-р ботид: Төв Ази, Монгол нутагт овог аймгийн нэгдэл бүрэлдэж, улмаар анхны төр улсын нэгдэл тогтож эхэлсэн цагаас Өвгө монголчуудын эзэнт гүрэн болох Хүннү гүрний үе, 3-р ботид: Хүннү гүрний задралын дараа Төв Ази, одоогийн хойд хятадад оршин байсан тархай бутархай овог аймгуудыг нэгтгэн захирч, НТ II-ҮI зууны хүртэлх хугацаанд тэдний соёл иргэншил хүчтэй нөлөөлсөн тухай, 4-р ботид: Их монгол улсын үе 1206 оноос 1271 он, 5-р ботид: Ази, Европ, Африк /Ливанти/-тивийн хэмжээнд одоогийнхоор 40 гаруй улсын нутаг дэвсгэрт буюу 24,5-28 сая км квадрат газарт оршин байсан овог аймаг, угсаатнуудыг түвшитгэн тохинуулж төр гүрнээ байгуулсан эхэн үе, 6-р ботид: Дөчин, Дөрвөн хоёрын монгол улсын үе /XIV-XV зуун/, 7-р ботид: Манж Чин улсын үеийн XV-XIX зуун буюу 1691-1860 он, 8-р ботид: Манж Чин улсын үеийн Монгол хийгээд Олноо Өргөгдсөн Монгол улсын үе, XIV зууны сүүлчээс XX зууны эхэн үе буюу 1861-1920 он, 9-р ботид: XX зууны үед Ар монголчуудын хийсэн үндэсний ардчилсан хувьсгалын үе хийгээд Монгол улс ЗХУ-ын нөлөөлөлд орсон цаг хугацаа, 1990-ээд оноос эхэлсэн өөрчлөлт шинэчлэлтийн үе, гэсэн эдгээр есөн боть номоо он дарааллын бичиг хэлбэрээр түүхлэн туурвижээ.

633/1/42

Б-22	Боть- 1. - 724 х.	/НХШУН унш -3ш/	Т-16029-16030
	Боть- 2. – 349 х.		Т-16031-16032
	Боть- 3. – 548 х.		Т-16033-16034
	Боть- 4. – 530 х.		Т-16035-16036
	Боть- 5. – 432 х.		Т-16037-16038
	Боть- 6. – 592 х.		Т-16039-16040
	Боть- 7. – 527 х.		Т-16041-16042
	Боть- 8. – 574 х.		Т -16043-16044
	Боть- 9. – 574 х.		Т-16045-16046



Кузьмин С.Л. **Барон Унгерны түүх**: Үнэнийг дахин сэргээсэн туршилт /Хян. О. Батсайхан., А.Р. Ефрименко, Орч. Ч. Баасанжаргал, Орч. Хян. Н. Балжинням. – УБ.: 2013. – 802 х.

Энэ номонд гадаад Монголын автономит засгийг тогтоосон, Барон Унгерны хүүхэд ахуй, залуу нас, түүний Орос-Японы болон дэлхийн 1-р дайнуудад оролцож явсан, мөн Азийн морьт дивизийг бүрдүүлэн зохион байгуулсан, Нармай монголын хөдөлгөөнийг өрнүүлж, гадаад Монголыг хятадын булаан эзлэгчдээс чөлөөлсөн, автономийг дахин тогтоосны дараах үеийн монголын байдал, Азийн морьт дивиз Сибирь рүү чиглэсэн довтолгоо, монголд гарсан хувьсгал, иргэний дайн, Унгерныг мөрдөн байцааж, хэргий нь шүүн тасалж, буудан хороосон, монголд байсан цагаантны бусад отрядын үйл ажиллагаа, монголын сүүлчийн их хаан-ҮШ Богд гэгээний амьдрал, үйл ажиллагаа, Унгернтай холбоотой домог яриа, зан чанар, шашин шүтлэг, нийгэм улс төрийн байр суурь, японтой тогтоосон харилцаа болон геополитикийн үйл ажиллагааны үр дүн гэх зэрэг олон зүйлсийн тухай дэлгэрэнгүй түүхийг өгүүлнэ.

63.3/1/6

К-89

НХШУН унш-3ш/

Т-16047-16048

Монголын сэргэн мандалтын эхэн: Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл /Эрх. Д. Мөнх-Очир, Ред. Ж. Урангуа. – УБ.: 2011. – 212 х.




Энэхүү эмхэтгэлд нь Үндэсний эрх чөлөөний хувьсгалын 100 жилийн ойд зориулсан “Монголын сэргэн мандалтын эхэн” сэдэвт Олон улсын эрдэм шинжилгээний хурлыг нээж МУ-ын тэргүүн шадар сайд АН-ын дарга Н. Алтанхуягын хэлсэн үг болон МУИС-ийн түүх, нийгэм-соёлын антропологи, археологийн тэнхимийн доктор, профессор багш нар, Удо Бархманн /ХБНГУ/, Х. Мэндсайхан /МУГСТ-ийн захирал/, БХЯ, ТЕГ, ХИС, МУБИС, тус тус сургуулийн доктор багш нарын илтгэлүүдийг багтаажээ.

63.3/1/6

М-69

/НХШУН унш -2ш/

Б-22322-22323



Монголын тусгаар тогтнол ба монголчууд: Олон улсын эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхэтгэл/ Улаанбаатар хот, 2011 оны 12 сарын 9-12 /Эмх. С. Чулуун. – УБ.: Мөнхийн үсэг, 2012. – 318 х.

Эмхтгэлд ХХ зууны Монголын түүхийн хамгийн сонирхолтой, ээдрээтэй, маргаантай асуудлыг хамарсан Монголын тусгаар тогтнол, улс төр, нийгэм, гадаад, дотоод орчин түүхэн зүтгэлтний үйл ажиллагааг олон талаас нь авч үзсэн эрдэмтдийн судалгаа юмаа. Энэхүү ном нь түүх сонирхон судлагч хэн бүхэнд зориулагдана.

63.3/1/6

М-69

/НХШУН унш-7ш/

Т-16051-16053

Мондоон Д., Мэндсайхан Х. **Номч билигт хувилгаан Дугарын Жамъянжамц** /Хян. Ж. Урангуа. – УБ.: Мөнх Дардас, 2012. – 84 х.



Энэхүү номыг “Гангын хувилгаан багш” хэмээн хүндлэгдэн алдаршсан Дарьгангын Номч билигт хувилгаан Дугарын Жамъянжамцын гэгээн дурсгалд нь зориулжээ. Номонд хувилгааны угсаа гарвал хийгээд өмнөх дүрүүд, багшийн уугуул нутаг, түүний үйл хэрэг, хэлмэгдэлт болон цагаатгал, төрөл төрөгсөд, шавь нартаа айлдсан айлдвараас нь оруулж өгчээ.

63.3/1/6

М-69

/НХШУН унш-3ш/

Б-22324-22325



Мөнх-Очир Д. **Монгол улсын аймаг, хошуу, сумын лавлах:** Хошуу ноёдын жагсаалт /1691-1925/ /Хян. Ж. Урангуа. – УБ.: 2012. – 125 х.

Уг лавлахыг нийт хүмүүст зориулан хуучин засаг захиргааны нэгжийн түүхэн он цагийг тухайн цаг үеийн нөхцөлд нь холбон тодруулж судлах, мөн түүний зэрэгцээ сүүлийн жилүүдэд угсаа гарвал, ах дүүгээ тодруулахыг хүсэгчид олширсон бөгөөд тэдгээр нь аав, ээж, өвгө дээдсээ хуучин засаг захиргааны нэгжээр аль аймаг хошуунд хамаарч байсныг тэр болгон тодорхой мэддэггүй тул энэхүү гарын авлагыг бичжээ.


63.3/1/я2

М-81

/НХШУН унш-7ш/

Б-22328-22330

Одбаяр О. **Зүүн хязгаарын Монголчуудын оюун санааны их удирдагч Егүзэр хутагт Ж. Галсандаш** /Ред. Ж. Урангуа. – УБ.: Бемби сан, 2012. – 118 х.




Монголын улс төр шашны төлөө бүхий л амьдралаа зориулсан хутагтуудын нэг Егүзэр хутагт Ж. Галсандаш тэрээр амьдарч ахуй цаг хугацаандаа элэг нэгт монголчуудаа эвсэн найрамдуулж, Их Монгол улсаа байгуулахын төлөө сэтгэл зүрхээ харамгүй зориулж явсан монгол төрийн суут хүн байсан аж. Егүзэр хутагт Халхын тамгатай хутагтын зиндаанд хүрсэн монголын бурханы шашны томоохон зүтгэлтэн, эрдэмтэн лам, олон шавь, сүсэгтнүүдийг энэрэн хайрлахуй, амьдрахуй ухаанаар хүмүүжүүлсэн сурган хүмүүжүүлэгч, төр засаг, улсынхаа тусгаар тогтнол, батлан хамгаалах хүч, хил хязгаар, үйл хэргийн төлөө амь бие хайрлалгүй зүтгэсэн нэрт цэргийн, дипломатч, Зүүн хязгаарын монголчуудын оюун санааны их удирдагч байжээ. Егүзэр хутагт Галсандаш хэмээх энэхүү суут хүний Монголын түүхэнд оруулсан ач гавьяа багагүй билээ.

63.3/1/6

О-19

/НХШУН унш-3ш/

Б-22326-22327



Тэрбиш Л. **Төвд хэлт түүхийн зохиолын сурвалж судлал-1: Энэтхэгт ном дэлгэрсэн түүх** /Төвд хэлн. Орч. Л. Тэрбиш, Хян. Д. Дашбадрах. - УБ. – 308 х.

63.3

Т-92

/НХШУН унш-7ш/

Б-22414-22416

ЭДИЙН ЗАСАГ

Чимгээ Д. **IDEA дээр аудитын шалгалт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн шинжилгээг хийх арга:** Аудитын шалгалтанд зориулсан өгөгдлийн шинжилгээний програм /Ред. Д. Хонгорзул. – УБ.: Арвай принт, 2012. – 192 х.



IDEA /өгөгдлийг шинжлэх, шинэ өгөгдөл гаргах гэсэн утгатай/ нь аудиторууд, нягтлан бодогчид, санхүүгийн

мэргэжилтэнүүдийг файл дээр бичигдсэн тайлан, компьютер зэрэг олон эх сурвалжаас өгөгдлийн файлыг импортлох, шаардлагатай өгөгдлүүдийг дэлгэцэнд харуулах, унших, шинжлэх, өөрчлөх, хэсэгчлэх, шинэ өгөгдлүүд гаргаж авах зэрэг өргөн хүрээний боломжуудаар хангаж өгдөг байна.

65с

Ч-62

/НХШУН унш-15ш/

Б-22356-22360



Чимгээ Д. **Хөрөнгө оруулалтын төслийн шинжилгээг EXCEL дээр гүйцэтгэх нь**: 3 дахь хэвлэл /Ред. Б. Сайнжаргал. – УБ.: Арвай принт, 2012. – 148 х.

Уг номонд хөрөнгө оруулалтын төслийн шинжилгээг EXCEL програмын санхүүгийн функцуудыг ашиглан хэрхэн гүйцэтгэж болох талаар авч үзсэн болно. Их дээд сургуулийн оюутнуудад “Хөрөнгө оруулалтын төслийн шинжилгээ” хичээлийг EXCEL програмын хэрэглээтэй холбон судлахад ашиглагдах сургалтын нэмэлт гарын авлага, багш нарт энд тусгагдсан сэдвүүдээр хичээл явуулахад туслах материал болж өгч чадна.

65с

Ч-62

/НХШУН унш-15ш/

Б-22351-22355

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ

Амарсанаа Ж. **Үндсэн хуулийн маргаан**: Анхны хэвлэл /Ред. Л. Баасан ба бус. – УБ.: 2012. – 812 х.




Энэ номноос үндсэн хуулийн цэцийн ажлын онцлог, хүрээ хязгаар, үйл ажиллагааны чиглэл, түүнчлэн иргэд төрөө жолоодох, хянахад оролцдог нэг чухал арга замыг мэдэж авахаас гадна монголын өнөөгийн хууль тогтоох байгууллага, бусад эрх мэдэл бүхий субъектын үйл ажиллагааны цараа, чадавхи, алдаа оноо, ажлын арга барилыг ямар нэг хэмжээгээр дүгнэх боломжтой. Мөн энэ номонд 2012 оны 12-р сарын 1-нээс өмнө Үндсэн хуулийн цэцээс гаргасан тогтоол, дүгнэлт оржээ.

67.400.1/1/

А-51

Т-16117-16118



Баасанжаргал А. **Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа: Анхдугаар хэвлэл** /Хян. Ц. Багмид. – УБ.: АМТА принтинг, 2012. – 442 х.

Энэ гарын авлагад хөдөлмөрийн салбарт мөрдөгдөж буй хууль, дүрэм, эрүүл ахуй, аюулгүйн байдлын менежмент, аюулгүй ажиллагаа, эрх зүйн асуудлыг иж бүрнээр нь, мөн өөрийгөө шалгах тест оруулжээ. Гарын авлагын бүлгүүдэд нь Монгол улсын хөдөлмөрийн хууль, эрх зүйн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хуулиас, эмнэлэгийн анхны тусламж, аюулгүй байдлын менежментийн танилцуулга, аюулыг мэдээлэх хөтөлбөр, хувийн хамгаалах хэрэгсэл, аюултай энергийг хянах хөтөлбөр, эргономик, уналтаас хамгаалах, цахилгааны аюулгүй ажиллагааны талаар цогцолбороор нь авч үзсэн байна.

67.405

Б-10

/НХШУН унш- 7ш/

Т-16129-16131

Булган Д. **Захиргааны шийтгэлийн онол, практикийн үндсэн асуудал.** – УБ.: Китаб, 2011. – 136 х.



Энэхүү ном нь гурван бүлэг, арван нэгэн зүйлээс бүрдэх ба хүний эрх, эрх чөлөөг хөнддөг анхаарал татсан сэдвийг хөндөн авч үзжээ. Эхний бүлэгт МУ-ын хууль тогтоомжинд захиргааны шийтгэл тусгагдаж ирсэн түүхэн уламжлал, шинэтгэл, 2-р бүлэгт захиргааны зөрчилд ногдуулж буй захиргааны шийтгэлийн өнөөгийн байдлыг шинжлэн үзэх нь, сүүлийн бүлэгт захиргааны шийтгэл ногдуулах ажиллагаа гэсэн эдгээр тухайлан судалсан бүтээл нь хууль зүйн дээд сургуулийн оюутны сургалт, захиргааны шийтгэл ногдуулж буй эрх бүхий албан тушаалтны өдөр тутмын хэрэгцээнд зориулагдана.

67.401

Б-72

/НХШУН унш-3ш/

Б-22339-22341



Бүгд Найрамдах Хятад Ард Улсын оюуны өмчийн эрх зүйд холбогдох хууль тогтоомжийн эмхэтгэл /Орч. Эмх. Б. Батбаяр., Т. Мөнхжаргал. – УБ.: 2012. - 132 х.

Толилуулж буй энэ оюуны өмчид холбогдох хууль тогтоомжийг БНХАУ-ын Өвөрмонголын өөртөө засах

орны Ардын хэвлэлийн хорооноос монгол бичгээр хэвлэсэн албан ёсны хуулийн эмхтгэлийг үндэс болгон орчин цагийн монгол хэлнээ хөрвүүлжээ. Энэ чиглэлээр судалгааны ажил хийдэг эрдэм шинжилгээний ажилтан, багш, оюутны сургалт, судалгаа хийгээд хуулийн төсөл боловсруулагчдад ч тус нэмэр үзүүлнэ.

67.404.3/Хят/

Б-81

/НХШУН унш-3ш/

Б-22313-22315

Нийтийн болон хувийн өмчийн эрх зүйн тулгамдсан асуудал /Эмх, Ред. Н. Лүндэндорж. – УБ.: Соёмбо принтинг, 2012. – 109 х.




Энэхүү бүтээлд нь өмч, өмчлөх эрхийн хүрээнд олон асуудал байсаар байгааг харгалзаж МУИС-ийн Хууль зүйн сургуулиас эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулж, хэлэлцүүлсэн илтгэлүүдийн эмхтгэлийг хэвлэж уншигч, олон нийт та бүгдэд зориулан хүргэжээ.

67.404.1

Н-61

/НХШУН унш-7ш/

Б-22390-22392



Скуратов Ю. **Владын амийг хэн егүүтгэв?** Оросын Холбооны Улсын Ерөнхий прокурорын өдрийн тэмдэглэл, эргэцүүлэл, баримт сэлтэд тулгуурлан бичсэн эрүүгийн роман /Орч. Ж. Амарсанаа, Хян. Д. Баянбилэг. – УБ.: 2003. – 268 х.

Юрий Скуратовын энэ номонд хорьдугаар зууны 1995-1998 оны үед төрийн болон эрүүгийн эрх мэдэл дээд цэгтээ хүрсэн тухай өгүүлнэ. Хэнээс ч хараат бус, олон нийтэд хүндлэгдсэн телевизийн нэрт хөтлөгч улс төр, эрүүгийн гэмт хэргийнхний хуйвалдааны голомт руу орж мафийн хүрээнийхний төдийгүй төрийн дээд эрх мэдэлтний мөн чанарыг илчлэх болсон юм. Тэд түүнийг эхлээд худалдан авах гэж үзээд, дараа нь айлган сүрдүүлэх гээд бүтэлгүй болохоор нь амийг нь егүүтгэжээ. Нэрт хөтлөгчийг зэрлэгээр хөнөөсөн хэргийг мөрдөн шалгасан тухай хувилбар болон бусад холбогдох мэдээллийг зохиогчийн зүгээс гарган тавьсныг уншигч та тунгаана уу.

67.52

С-46

Б-22417-22418

Эрүүгийн хэрэг: Эрх зүйн баримт бичгийн эмхтгэл. – УБ.: 2013. - 540 х.




Эрүүгийн хэрэг гэсэн энэхүү эмхтгэлд Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хуульд шууд хамааралтай Үндсэн хуулийн цэцийн шийдвэр, Улсын дээд шүүхийн тогтоолоор баталсан тайлбар, мөн зөвлөмж, түүнчлэн хэргийг хянан шийдвэрлэх, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавихтай холбогдуулсан Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор, Хууль зүйн сайд /хуучнаар хууль зүй, дотоод хэргийн сайд/, бусад сайдаас дангаараа болон бусадтай хамтран баталсан эрх зүйн хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг 2012 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар нэгтгэн оруулжээ.

67.408

Э-80

T-16119-16120

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БҮТЭЭЛҮҮД



Антропологи, археологи, угсаатан судлалын эрдэм шинжилгээний бичиг: Боть-7, №1/378/ 12-2012 /Эмх. М. Эрдэнэ. – УБ.: МУИС-ийн хэвлэх, 2012. – 187 х.

Энэхүү дугаартаа “Дорнод Монгол -2011” археологийн хээрийн судалгаа, Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын нутгаас шинээр олж илрүүлсэн буган хөшөөд, Баянтүмбийн хадны зургийн дүр, дүрслэл, гэх мэт эртний бичээс, булш, хадны зураг, чулуун хөшөө, хөлөгт тоглоом, зэрэг аймаг сумдаас олдсон судалгааны талаар монгол, орос, англи хэл дээр өгүүлэлүүдээ бичиж гаргажээ.

72

А-65

/НХШУН унш-3ш, Лав-1ш/

T-16110-16111

Лодой Г. Шинжлэх ухааны судалгааны логик-арга зүйн асуудлууд: Магистрантур, докторантурын сургалтын хэрэглэгдэхүүн. – УБ.: 2012. – 136 х.



72в6

Л-69

/НХШУН унш-15ш/

Б-22366-22370



Монгол судлалын чуулган: Эрдэм шинжилгээний сэтгүүл Дэвтэр1-28, 2012/2 №13/48/, МУБИС. МСС /Эрх. Хөвсгөл. – УБ.: Жиком пресс, 2012. – 229 х.

МУБИС-ийн МСС-аас гаргасан энэхүү дугаартаа хэл шинжлэл, уран зохиол судлал, ардын аман зохиол, соёл судлал, сэтгүүл зүй, мэдээ, тэмдэглэл зэргийн талаар професор, доктор багш нарынхаа бичсэн эрдэм шинжилгээний өгүүллүүдийг өргөн барьжээ.

72

М-69

Т-16079-16080

Нийгмийн шинжлэх ухааны эрдэм шинжилгээний бичиг №7/6/: МУИС.Улаанбаатар Сургууль. – УБ.: Соёмбо принтинг, 2011. – 204 х.



72

Н-58

/Лав-1ш/

Т-16081



Технологийн салбарын эрдэм шинжилгээний бичиг №7/6/: МУИС. Улаанбаатар Сургууль. – УБ.: Соёмбо принтинг, 2011. – 124 х.

МУИС-ийн Улаанбаатар Сургуулийн Технологийн салбарын эрдэм шинжилгээний бичгийн 7 дахь дугаартаа энэ салбарын багш нарын болон МУИС, МУБИС, ОХУ-ын ШУА, А.Н.Северцовын нэрэмжит Экологи, эволюцийн хүрээлэн, Дагистаны салбар, Биологийн нөөцийн хүрээлэн, ХИС, НЭМХ, хими, хими технологийн хүрээлэн, ШУТИС-ийн Өвөрхангай аймаг дахь Технологийн сургууль, Ханойн их сургуулийн химийн тэнхим, ШУА-ийн Биологи, Ботаникийн хүрээлэнгийн эрдэмтдийн бичсэн эрдэм шинжилгээний өгүүллийг эмхтгэн гаргажээ.

72

Т-36

/Лав-1ш/

Т-16083

Хэл бичиг, утга соёл эрдэм шинжилгээний бичиг №7/6/: МУИС. Улаанбаатар Сургууль. – УБ.: 2011. – 134 х.



МУИС-ийн Улаанбаатар Сургуулиас гаргаж байгаа энэ 7 дахь дугаартаа хэл зохиолын факультетийн багш нарын болон өвөрмонгол, буриад, монгол эрдэмтдийн хэл бичиг, утга соёлын талаар бичсэн өгүүллийг толилуулж байна.

72

Х-89

/Лав-1ш/

T-16082



Эрдэм шинжилгээний бичиг: Социологи №8/377/ МУИС. НШУС. Социологи, нийгмийн ажлын тэнхим /Эрх. О. Мөнхбат. – УБ.: МУИС-ийн хэвлэх, 2012. – 222 х.

Энэхүү сэтгүүлийн дугаарт социологийн онол, түүх, судалгааны арга техник, салбар социологи, тодорхой судалгаа, залуу судлаачдад гэсэн сэдвийн хүрээнд социологийн нийгмийн ажилтны тэнхимийн доктор багш нарын бичсэн эрдэм шинжилгээний өгүүллийг нь багтаасан болно.

72

Э-72

/НХШУН унш-2ш, Лав-1ш/

T-16049-16050

БОЛОВСРОЛ, СУРГАЛТ, СУРГАН ХҮМҮҮЖҮҮЛЭХ ЗҮЙ

Боловсролын философи /Ред. Н. Бэгз., О. Пүрэв. – УБ.: Соёмбо принтинг, 2012. – 408 х.



Монгол Улсад боловсролын философийн судалгаа шинэ тутам хөгжиж байна. Харин хуучин тогтолцооны үед гол төлөв социалист зан төлөв, коммунист ёс суртахуунд үндэслэгдэн ертөнцийг үзэх үзлийн номлолыг хүний хөгжлийн үзэл баримтлал болгож байжээ. Иймээс энэхүү бүтээлээ дөрвөн үндсэн бүлгүүдэд хуваан авч үзжээ. Үүнд: 1-р бүлгээ философийн хүрээн дэх боловсролын асуудлууд, 2-р бүлгээ боловсролын хөгжлийн философи үзэл санаа, 3-р бүлгээ монголчуудын уламжлалт сурган хүмүүжүүлэх философи сэтгэлгээний өвөөс, 4-р бүлгээ багш бэлтгэх сургуулийн

“боловсролын философи” сургалтын хөтөлбөрийн үндэслэл, үзэл баримтлал гэсэн эдгээр ерөнхий бүлэгт хуваан судалжээ.

74.03

Б-55

Т-16067-16069



Даваа Ж. **Их, дээд сургууль, коллежийн сургалтын хөтөлбөр боловсруулах арга зүй: Анхны хэвлэл** /Хян. Г. Сарантуяа. – УБ.: Артсофт, 2012. – 67 х.

Тус номонд их, дээд сургууль, коллежийн сургалтын болон судлагдахууны хөтөлбөр боловсруулах ажил, түүний шинэчлэлийн асуудлыг онол арга зүйн талаас нь үзжээ. Дээд боловсрол эзэмшүүлэх сургалтын агуулга, арга зүйгээ боловсронгуй болгохыг эрмэлзэж байгаа их, дээд сургууль, коллежийн удирдах ажилтан, багш нар, боловсрол судлалын оюутан, магистр, доктор болон дээрх асуудлыг сонирхсон хүн бүрт зориулагдана.

74.58

Д-12

/НХШУН унш-7ш/

Т-16073-16075

Даваа Ж. **Сурган хүмүүжүүлэх зүй** /Хян. Л. Жамц. – УБ.: Артсофт, 2012. – 163 х.



Энэхүү номонд нь сурган хүмүүжүүлэх зүйн хөгжил, хандлага, зорилго, сурган хүмүүжүүлэх үйл явц, зохион бхйгуулах арга зүй, хүүхдийн танин мэдэх хэрэгцээ, сурах арга, боловсролын тусгай хэрэгцээтэй хүүхэд хүмүүжүүлэх, онол арга зүй, бие хүний хөгжил, төлөвшил, боловсрол, тэдгээрийн холбоо хамаарал, эцэг эх, асран хамгаалагчидтай ажиллах арга зүй, багшийн сэтгэл зүйн онцлог, имидж, багш үйл ажиллагаа, судалгаа шинжилгээний ажил, багшийн ажлын үнэлгээ, багшийн хөгжил, ерөнхий боловсрол эзэмшүүлэх сургалтын агуулга, арга зүй, сургалтын орчин үеийн загвар зэрэг асуудлыг хамруулсан тул багш нар, боловсрол судлалын чиглэлээр сурч буй бакалавр, магистр, доктор болон дээрх асуудлыг сонирхсон хүмүүс ашиглах боломжтой.

74.0

Д-12

/НХШУН унш-25ш/

Б-22371-22375



Амьтан судлалын тэнхим: 70 жилийн түүхэн замнэл
/Эмх. Б. Баяртогтох. – УБ.: Мөнхийн үсэг, 2012. – 119 х.

Анх 1942 онд МУИС байгуулагдаж, түүний бүрэлдхүүнд бий болсон ууган 8 тэнхимийн нэг нь Амьтан судлалын тэнхим юм. Тухайн үед үндэсний дээд боловсролтой амьтан судлаач байхгүй учраас эхний жилүүдэд ЗХУ-ын эрдэмтэн багш нар урилгаар ирж ажиллаж байжээ. Амьтан судлалын тэнхим нь 1951 оноос хими-биологийн багш, 1963 оноос амьтан судлал, 1973 оноос агнуур зүй, 1990 оноос шавьж судлал, 1991 оноос экологи зэрэг чиглэлүүдээр мэргэшүүлэх сургалт явуулж эхэлсэн түүхтэй. Энэ нь тус тэнхимийн Монгол улсад биологийн шинжлэх ухаан үүсч хөгжих эхлэл, үндэс суурь болсны илэрхийлэл юм. Тус тэнхимийг төгссөн олон зуун мэргэжилтэн шинжлэх ухаан, боловсрол, эрүүл мэнд, хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн болон бизнесийн салбарт ажиллаж байгаа бөгөөд тэнхимийн үе үеийн багш ажилтнууд төгсөгчдөөрөө бахархаж байдаг.

74.58

А-58

Т-16090-16091

Ургамал судлалын тэнхим: 50 жилийн түүхэн замнал
/Эмх. Д. Суран ба бус. – УБ.: Соёмбо принтинг, 2013. – 123 х.




МУИС үүсч байгуулагдсан 1942 оноос эхлээд багш нарын анги, 1951 онд хими-биологийн анги, 1955 онд биологийн анги нээж дунд сургуульдаа дээд боловсролтой багш, үйлдвэрлэл судалгааны ажилд амьтан судлаач, ургамал судлаач мэргэжилтэнг бэлгэж эхэлжээ. 1963 оны 1-р сарын Ректорын тушаалаар хэд хэдэн факультет, тэнхим зохион байгуулагдсаны нэг нь Ургамал судлалын тэнхим юм. Тэнхимийн гол зорилго, үүрэг нь эх орондоо үндэсний дээд боловсролтой ургамал судлаач, мэргэжилтэн, багш нарыг бэлтгэх ажил байжээ. Манай улс зах зээлийн эдийн засагт шилжсэний дагуу тэнхимийн үйл ажиллагаанд тодорхой өөрчлөлт орж байгаа ч үндсэн гол зорилго ч цаашид мөн үргэлжилэх болно.

74.58

У-47

Т-16088-16089

БУЛЧИН ХӨГЖҮҮЛЭХ ДАСГАЛ, СЭТГҮҮЛ ЗҮЙ, МУЗЕЙ СУДЛАЛ



Цэрэнбат Э., Цолмонтуяа Д. **Бодибилдингийн дасгалаар булчин хөгжүүлэх зурагт ном** /Ред. С. Энэбиш. – УБ.: Хуст, 2013. – 130 х.

Хүний биеийн бүтцээс булчингийн бүтцийг илүү тусгасан бөгөөд ямар дасгал аль булчинд хэрхэн нөлөөллөхийг илүү дэлгэрэнгүй харуулжээ. Ийм учраас зөвхөн бодбилдингээр хичээллэгчдэд төдийгүй хүний биеийн тулгуур хөдөлгөөний тогтолцоог сонирхон судлах хэнд ч хэрэгцээтэй ном болжээ.

75.6

Ц-96

T-16126-16128

Зулькафиль М. **Эрэн сурвалжлах сэтгүүл зүйн онол, практик: Нэмж засварласан 3 дахь хэвлэл** /Ред. Хүрэлбаатар Ү., Ч. Чойсамба. – УБ.: Ганзам м



Эрэн сурвалжлах сэтгүүл зүйн талаарх сэтгүүлчдийн мэдлэг, арга барилыг ахиулах, учирч буй саад бэрхшээл, тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд туслах зорилгоор энэ нэмж засварласан номыг шинэчилж, шинэ баримт мэдээллээр баяжуулан хуучирсан жишээ баримтыг хасч, эрэн сурвалжлах сэтгүүл зүйн үүсэл хөгжил, эрэн сурвалжлага хийх арга зэрэг хэсэг бүлгийг нь шинэчилж залуу сэтгүүлчид зайлшгүй анхаарах арга зүйн зөвлөмжийг нэмж оруулж өгчээ.

76.01

3-80

/НХШУН унш-7ш/

Б-22408-

22410



Норовсүрэн Л. **Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм: Нэмж засварласан хоёр дахь удаагийн хэвлэл** /Ред. М. Зулькафиль., Ч. Чойсамба, Хян. Ч. Чойсамба. – УБ.: МУИС-ийн хэвлэх, 2012. – 430 х.

76.01/1/

Н-74

/НХШУН унш-7ш/

Б-22381-22383

Норовсүрэн Л. **Фото сэтгүүл зүй: Их, дээд сургуулийн сэтгүүлчийн ангийн оюутан, гэрэл зурагчид, сонирхогчдод зориулав** /Ред. Н. Ариунзаяа. – УБ.: 2012. – 299 х.



Монгол улсад үндэсний сэтгүүл зүй үүссэний 100 жилийн ойд зориулан гаргажээ.

76.01

Н-74

/НХШУН унш-7ш/

Т-16070-16072



Нэргүй Ж. **Ясан хуягт мэлхий их далайг зоримой** /Задгай голдуу нийтлэлүүд/. – УБ.: Эзэн сүлд, 2013. – 260х.

Зохиогч энэхүү бүтээлдээ шилж, сонгож түүвэрлэсэн нийтлэлүүдээ ирээдүйн сэтгүүлчдэд хандуулан бичжээ.

76.01

Н-93

Б-22411-22413

Байгалийн үзмэрүүдийг цуглуулах аргазүй: Орон нутаг судлах музейнүүдийн эрдэм шинжилгээний ажилтнуудад зориулсан гарын авлага. – УБ.: Xpress, 2011. – 40 х.




79.1

Б-17

Б- 22394-22396

ҮГСИЙН САН СУДЛАЛ, АМАН ЗОХИОЛ СУДЛАЛ



Бат-Ирээдүй Ж., Алтансайхан Р. **Монгол хэлний адитгал үг, хэллэгийн сан** /Эрх. До. Цэнджав, Хян. Ч. Нацагдорж., Т. Ууганбаяр. – УБ.: Мөнхийн үсэг, 2012. – 237 х.

Адитгал бол хүний танин мэдэх, ухаарал, сэтгэхүй, сэтгэлгээний үр дүнгийн илэрхийлэл бөгөөд уламжлал удамшил, зан заншил, соёл түүхийн ялгаанаас шалтгаалан улс үндэстэн бүрд өөр өөр байдаг. Энэ номондоо уран зохиолын 400 орчим өгүүллгийг шүүн үзэж, аль болох хангалттай жишээ баримтанд тулгуурлан монгол хэлний адитгал үг хэллэгийн ерөнхий болон

өвөрмөц онцлогийг ажиглаж, адитгал үгийн онцлог, монгол хэлний жиших адилтгах зэргийг авч үзжээ.

81.2М-3

Б-33

/НХШУН унш-15ш/

Б-22331-

22335

Ганцэцэг С. **Монгол оньсогын ангилал, туурвилзүйн онцлог**: Анхны хэвлэл /Хян. Ж. Батбаатар., Оюунбадрах. – УБ.: Битпресс, 2013. – 152 х.



Доктор С. Ганцэцэг нь 2010 онд эрдмийн зэрэг горилсон бичсэн ажлаа нийтийн утга зохиолын хэм хэмжээнд нийцүүлэн засварлаж, “Монгол оньсогын ангилал, туурвилзүйн онцлог” хэмээх номоо уншигчдадаа толилуулж байна.

83.3/1/

Г-23

/НХШУН унш- 3ш/

Б-22406-22407

УРАН ЗОХИОЛ

Баярцэнгэл Ж. **Залхах завгүй хорвоо** /Хян. П. Бадарч. – УБ.: Мөнхийн үсэг, 2012. – 224 х.

84/1/2-5

Б-38

/НХШУН унш-5ш/

Б-22336-22338

Ганбат Р. **Зохиолын найман боть эмхэтгэл** /Ред. Д. Цоодол. – УБ.: Соёмбо принтинг, 2008.



Сэлэнгэ нутгийн авьяаслаг нэрт зохиолч, орчуулагч Р. Ганбатын найман боть бүтээлүүдийг нь эрхэм уншигч та бүхний өмнө дэлгэж байна.

84/1/2-44

Г-21

Хургалгын амны жимс исгэлэн/новеллууд/. – 436 х. Б-22419

Зөвхөн марал мичид л мэднэ/новеллууд/. – 442 х. Б-22420

Сүүлчийн галт тэрэг/кино тууж/. – 474 х. Б-22421

Амьд явах хэрэгтэй!/роман/. – 468 х. Б-22422

Ирэх хаврын цэцэг/кино зохиол,жүжиг/. – 574 х. Б-22423

Шархатсан чулуу/орчуулга/. – 334 х. Б-22424

Бадамлянхуа цэцгэн эрхи/орчуулгын роман/. – 420 х. Б-22425

Ирээдүйд тэмүүлэгсэд. – 506 х.

Б-22426

/түүхэн тэмдэглэл, найруулал, эссе, бодрол, хөрөг/



Гантулга Ё. **Монгол зураг.** – УБ.: УИХ-ын Тамгын газрын хэвлэх, 2011. – 204 х.

84/1/2-44

Г-23

/НХШУН унш-7ш/

Б-22310-22312

Лү Шюний шагналт зохиолын сонгомол түүвэр:

1.2.3.4. /Орч. Түмэндалай ба бус, Хян. Х. Оюунчулуун., П. Батцэцэг. – Өвөрмонгол.: Хөх хотын Баян, 2011.



БНХАУ, Монгол улсын хооронд соёлын харилцааг улам зузаатгахын төлөө ӨМӨЗО-ны Засгийн газрын Хэвлэл Мэдээллийн Албанаас эрхлэн “Лү Шюний шагналт зохиолын сонгомол” ботийн цувралыг Монголын уншигчдад өргөн барьж байна. Лү Шюнь бол Хятадын шинэ үеийн уран зохиолыг үндэслэсэн аугаа их шинэчлэгч юм. Тэрээр 1881-1936 оны хооронд амьдарч маш олон зохиол бүтээл туурвиж, хятадын уран зохиолын шинэ цаг үеийг нээжээ. Энэхүү шагналыг Хятадын Зохиолчдын Эвлэлээс голлон шалгаруулдаг байна. Лү Шюний утга зохиолын шагналд тодорсон бүтээлүүдээс түүвэрлэн энэхүү дөрвөн ботийг орчуулж, түмэн олонд толилууулж байна. Эдгээр ботид сонгогдон орсон 50 гаруй бүтээл нь Хятадын өөр өөр цаг үеийн хот хөдөөгийн амьдрал ахуй, хүн ардын хувь тавиланг олон талаас нь харж, ялануяа өөрчлөлт шинэчлэлтийг өрнүүлсэн гучин жилийн турш, цаг үеийн өөрчлөлтийг даган хүн ардын үзэл бодол, зан заншил, цаашилбал хувь тавиланд нөлөөлсөн олон өөрчлөлт хувирлыг тод томруун урлан бүтээснээрээ онцлогтой.

84/5Хят/-44

Л-86

Өгүүллэгийн түүвэр- 1. – 315 х.

Т-16059-16060

Найрууллын түүвэр- 2. – 288 х.


Т-16061-16062

Шүлгийн түүвэр- 3. - 300 х.

Т-16063-16064

Мэдээллийн уран зохиолын түүвэр -4. – 293 х. Т-16065-16066

ШАШИН СУДЛАЛ, СОЁЛ УРЛАГ СУДЛАЛЫН НОМЗҮЙ



“Байгаль экологи-хөгжил” сэдэвт хойд бүсийн буддистуудын бага хурал. – УБ. – 306 х.

Шашин ба Байгаль Хамгааллын Холбоо дэлхийн банктэй хамтран “Байгаль Эколгой-хөгжил” сэдэвт Хойд бүсийн Буддистуудын бага хурлыг манай оронд зохион явуулжээ. Хуралд манай хөрш зэргэлдээх орнууд болон МУ-ын өнцөг бүрээс ирсэн лам хуврагууд, сүсэгтэн олонд буддизм, буддын шашинтнуудын байгаль хамгаалал ба хөгжилд оруулах хувь нэмрийн талаар санал бодлоо солилцох онцгой завшаан гарчээ. Энэ хурал нь сүм хийд, нийгэмлэгүүд, байгаль орчны байгууллагууд, Засгийн газар зэрэг оролцогчдын хамтын ажиллагааны төрөл бүрийн шинэ санаачлагын эхлэл гэж үзжээ.

86.35

Б-17

Б-22398

Овоо босгон тахих ёс ба лус савдагийн тухай: Төвд хэл дээрх зохиолууд /Төвд хэлн Орч. Т. Булган., Д. Нямсамбуу, Ред. П. Санжид. – УБ.: Интерпресс. – 149 х.



Энэхүү номыг Шашин ба Байгаль Хамгааллын Холбоо болон Гандан тэгчэнлин хийдтэй хамтран “Монголын Уламжлалт Байгаль Хамгаалах Зан Үйл” цувралын дөрөв дэх дэвтрийг хүргэж байна. Энэ уламжлалт овоо тахих зан үйл болон лус савдагийн тухай бүрэн төгс ойлголтгүйгээс байгальтай зүй бусаар харьцах сөрөг үр дагавар авчирч буй хүний үйл ажиллагааг буруулах мөн эх дэлхийгээ хайрлан хамгаалах эрмэлзлэл төрүүлэх үүднээс энэ номыг олны хүртээл болгожээ.

86.35

О-14

Б-22397



Соёл урлаг судлалын номзүйн бүртгэл: Цуврал-1 /Ред. Д. Даваасүрэн. – УБ.: Мөрөөдлийн гурвалжин, 2013. – 184 х.

Энэхүү соёл урлаг судлалын номзүйн бүртгэл нь цаг хугацааны хувьд 1911-2011 оныг хамрана. Тиймээс энэ номзүйн

бүртгэлдээ 100 жилд соёл, урлаг судлалын чиглэлээр манай улсад гарсан ном, илтгэл, өгүүлэл, тус салбараас гарсан эрдэмтэн судлаачдын эрдмийн зэрэг горилсон бүтээлүүд багтана.. Энд соёлын салбараас музей, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, урлагаас дүрслэх, театр болон хөгжмийн салбарыг хамруулжээ. Харин соёлын болон урлагын бусад салбарт гарсан ном товхимол, илтгэл, өгүүлэл энд ороогүй болно.

91.9

С-52 /НХШУН унш-3ш, Лав-1ш/

Т-16124-16125

ОРОС , АНГЛИ, ХЭЛ ДЭЭРХ НОМ

Монгольско-Российское научное сотрудничество: от Ученого комитета до Академии наук /Ред. С. Чулуун., Т.И. Юсупова. – УБ.: Адмон, 2012. – 182 с.




В материалах сборника на примере деятельности монгольских и российских ученых в Монголии и для Монголии показаны особенности установления и развития монгольско-российского научного сотрудничества, рассмотрен их вклад в создание естественно-научных и гуманитарных направлений монгольской науки и изучение страны. Используемые при подготовке статей многочисленные архивные материалы помогают раскрыть влияние сложных исторических процессов, происходивших в монгольском обществе, на деятельность Ученого комитета и его взаимодействие с российскими исследователями и научными учреждениями в этот период, демонстрируют искреннюю заинтересованность российских ученых в работе в Монголии, в контактах с монгольскими коллегами. Сборник адресуется историкам науки, монголооведам, а также всем, кто интересуется историей Монголии в XX веке и монгольско-российского сотрудничества.

63.3/1/

М-77 /НХШУН унш-3ш/

Б-10174-10175



Namsrai Kh. **Derivation universal formulas for calculation of some definite integrals by hand.** – UB.: ЭжИМТО, 2013. – 248 p.

In this book, we will show that there exist concrete unified formulas by using that one can calculate enormous number of integrals by hand like one uses the Pythagorean Theorem. It turns out that according to our derived universal formulas there exists enormous number of equivalent integral which differ from each other by constants. In our approach taking integrals becomes design culture, since by appropriate choices of parameters entering into universal formulas one can obtain nice compact solution for integrals.

22.161.1

N-20

13345-13349

[ЯПОНЫ УРАН ЗОХИОЛ /ГЕРМАН ХЭЛ ДЭЭР/](#)

Hideo Lery. **Shinjuku Paradise:** Roman. – Japan.: 2012. – 223 p.

84/5Jap/-44

H-65

13356

Kyotaro Nishimura. **Das klatschende affchen.**- Japan.: Angkor Verlag, 2012. – 185 p.

84/5Jap/-44

K-99

13353

Osamu Dazai. **Die teufel des tsurugi-bergs.** – Japan.: 2012. – 174 p.

84/5Jap/-44

O-83

13355

Taeko Tomioka. **Wogen.** – Japan.: Angkor Verlag, 2012. - 180 p.

84/5Jap/-44

T-12

13352

Takehiko Fukunaga. **Des Grases Blumen.** – Japan.: Angkor Verlag, 2012. – 210 p.

84/5Jap/-44

T-16

13351

Wahei Tatematsu. **Erfrorene Traume.** – Japan.: Angkor Verlag,
2012. – 167 p.

84/5Jap/-44

W-15

13354

Jesus Christ: **Message to All Nations.** – America.: 2012. – 854 p.

86.37

J-44

13350